



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/33/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд сум 2019 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734      Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг Утас: 70523020      Цахим хаяг: enhtsetsege@audit.gov.mn Аудитор:              У.Оюунтүлхүүр Утас: 70523020      Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ .....</b>	<b>3</b>
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.19 № 1-6/90

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА Р.БОЛДБААТАР  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


010020038

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Р.Болдбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эмнэлгийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэх ёс зүйтэй харьцаа хандлагыг дээдэлсэн төрийн үйлчилгээний манлайлагч байгууллага байхад оршино”

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн асуудлаар дээд шатны байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах
- Үйл ажиллагаандаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж дүрэм заавар, стандарт удирдамжийг мөрдөх
- Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох
- Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
- Эмнэлгийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн гүйцэтгэлийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаанд нь мэдээлж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой эргэх мэдээллээр хангах
- Хүн амын эрүүл мэндийн хамгаалах дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийг идэвхтэй оролцоог хангаж, хамтарч ажиллах
- Эрүүл мэндийн талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭМС-ын 2019 оны 282 тушаал

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд асолуос программ хангамж ашигладаг байна.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1606,608.1 мянган төгрөгөөс тооцон 16,066.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17,111.6 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үеийн суурийг хэвээр авсан бөгөөд тайлант үеийн ашигтай холбоотой өссөн байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104554.9 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	2292.1	1096.1	-1196
Урьдчилгаа			0
Бараа материал	167856.8	251955.8	84099
Үндсэн хөрөнгө	1436459.1	1458111.1	21652
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1606608.1</b>	<b>1711163</b>	<b>104554.9</b>
Өр төлбөр			0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1606608.1	1711163	104554.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1606608.1</b>	<b>1711163</b>	<b>104554.9</b>

Авлага дансны үлдэгдэл 1196.0 мянган төгрөгөөр буурсан. 2015 онд үүссэн цалингийн зөрүүний авлага 123.8 мянган төгрөгийн авлага барагдуулж ХХАОТ болон НДШ-ийн авлагыг тухайн жилд 1072.2 мянган төгрөгөөр бууруулсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд НДШ 6.2 мянган төгрөг, ХХАОТ-ын 1089.9 мянган төгрөг, нийт 1096.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 84099.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд Тусгай зориулалтын материал 3871.0 мянган төгрөгөөр, эм боох материал 68525,9 мянган төгрөгөөр, ААМатериал 8332.5 мянган төгрөгөөр, Түлш шатахууны зардал 2701.0 мянган төгрөгөөр, Бусад хангамжийн материал 2083.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Энэ нь 2019 онд эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлын төлөвлөгөө эмнэ оноос 934,435.8 мянган төгрөгөөр, Түлш шатахууны зардал 9777.5 мянган төгрөгөөр, Хоол хүнс 9855.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 1565,0 мянган төгрөгөөр өсч батлагдснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд 24959.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8450.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 37209.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, Хандив, тусламжийн орлогоор нийт 135540.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй.

Тайлант онд өр төлбөргүй ажилласан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 2,458,884.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,460,798.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж гүйцэтгэл 99,9 хувьтай байна.

Хүснэгт 2. Санхүүжилтийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	1,141,720.4	1,141,720.4	0.0	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,284,578.3	1,284,578.0	-0.3	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,585.9	34,499.9	1,914.0	105.9
<b>Нийт дүн</b>	<b>2,458,884.6</b>	<b>2,460,798.3</b>	<b>1,913.7</b>	<b>100.0</b>

Үндсэн үйл ажиллагааны орлого 1,914.0 мянган төгрөгөөр давсан нь төлбөртэй тусламж үйлчилгээний орлого сайн байснаас шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,458,884.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,458,884.6 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,141,720.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,284,578.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 32,585.9 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 1.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,456,608.7 мянган төгрөг буюу 99.91 хувьтай байгаа нь Цалингийн зардал 471.3 мянган төгрөгөөр, Байр ашиглалттай холбоотой зардал 2188.6 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлаас 784.2 мянган төгрөгөөр, томилолтын

зардал 5.7 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил 32.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт зардлын хэмнэлт 3487.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлого 1913.7 мянган төгрөг нийт 5401.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар АЗДТГ-ын нөөц сангаас 500.0 мянган төгрөг, Замын-Үүд сумын ЗДТГ-аас 1000.0 мянган төгрөгийг хөнжил гудас авахад, ХӨСҮТ-өөс 1744.8 мянган төгрөгийг сорьц баталгаажуулах зардалд, ЭМДЕГазраас 18064.0 мянган төгрөгийг багцын шинжилгээний зардалд, ЭМЯамнаас давсан орлого 29789.1 мянган төгрөгийг санхүүжилт дутсан зардлыг төлөхөд зориулан нийт 51098.0 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Нийт 51081.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 16.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 191,478.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 191,306.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 172.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цалингийн программаас гүйлгээ алдаатай татагдснаас цалингийн зардал, НДШ зөрүүтэй бүртгэгдсэн байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,573.4 мянган төгрөгийн зөрчилд 2,573.4 төлбөрийн акт тогтоосноос 1674.7 мянган төгрөгийг барагдуулсан байна. 898.7 мянган төгрөгийн актны төлбөр төлөх ажилтан ажлаас гаран гадаад явсан тул одоо болтол барагдаагүй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Зардлын данстай холбоотой асуудал**

- 1.1. *Илрүүлэлт: Цалингаас суутгасан 172.9 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас шилжүүлсэн.*
- 1.2. *Эрсдэл: Батлагдсан төсвийн зардлын бүлгийн дүн хэтрэх*
- 1.3. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар батлагдсан журмын дагуу зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах*
- 1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн*

**2. Балансын данстай холбоотой асуудал**

- 2.1. *Илрүүлэлт: Бараа материалыг бүртгэхдээ дансны ангилал буруу хийсэн*
- 2.2. *Эрсдэл: Холбогдох зардлыг үр дүн буруу илэрхийлэгдэх*
- 2.3. *Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 тушаалд заасны дагуу үндсэн бараа материалыг ангилан бүртгэх*
- 2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>170148933.00</u></b>	<b><u>256851900.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,292,086.16	1,096,096.82
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,292,086.16	1,096,096.82
3351	Байгууллагаас авах авлага	2,168,251.16	1,096,096.82
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	3,800,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	3,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	167,856,846.84	251,955,803.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	120,180,403.96	192,577,383.21
35110	Тусгай зориулалттай материал	53,521,021.60	57,392,021.60
35130	Эм боох материал	66,659,382.36	135,185,361.61
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	47,676,442.88	59,378,420.50
35410	Бичиг хэргийн материал	20,000.00	174,000.00
35420	Аж ахуйн материал	44,371,385.88	52,703,985.88
35440	Түлш, шатах тослох материал	775,000.00	3,476,000.00
35450	Барилгын засварын материал	9,309.00	9,309.00
35460	Хүнсний материал	2,230,118.00	660,985.62
35470	Бусад хангамжийн материал	270,630.00	2,354,140.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,436,459,127.80</u></b>	<b><u>1,462,111,120.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,436,459,127.80	1,462,111,120.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,202,389,377.94	1,228,074,371.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	622,451,142.03	622,451,142.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,035,611.80	-2,355,971.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,647,037.15	208,647,037.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,374,473.27	-39,981,259.43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	903,546,177.49	1,064,046,437.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-559,090,952.73	-679,813,400.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,609,445.67	45,059,445.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,951,921.26	-25,937,177.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,588,534.66	42,588,534.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-6,630,417.90
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	234,069,749.86	234,036,749.86
39301	Програм хангамж	1,675,000.00	1,675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,605,250.14	-1,638,250.14
39303	Бусад биет бус хөрөнгө	234,000,000.00	234,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,606,608,060.80</u></b>	<b><u>1,718,963,021.48</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,606,608,060.80</u></b>	<b><u>1,718,963,021.48</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,606,608,060.80	1,718,963,021.48

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	949,893,092.00	949,893,092.00
51101	Өмч: - төрийн	949,893,092.00	949,893,092.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	385,985,843.66	498,340,804.34
51210	Өмнөх үеийн үр дүн	385,985,843.66	385,985,843.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	112,354,960.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	270,729,125.14	270,729,125.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,606,608,060.80</u></b>	<b><u>1,718,963,021.48</u></b>

## 1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,268,635,615.15</b>	<b>2,666,091,670.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>231,723,131.15</b>	<b>188,695,221.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	64,608,122.15	55,741,861.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,608,122.15	55,741,861.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,928,512.00	34,499,949.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,679,610.15	21,241,912.80
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	167,115,009.00	132,953,360.00
122001	Хандив тусламж /дотоод/	167,115,009.00	66,953,360.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	66,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,036,912,484.00</b>	<b>2,477,396,449.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	932,756,100.00	1,141,720,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	932,756,100.00	1,141,720,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,087,684.00	51,098,002.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,994,184.00	2,244,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,093,500.00	47,853,152.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,074,068,700.00	1,284,578,047.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,074,068,700.00	1,284,578,047.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,098,544,031.72</b>	<b>2,553,736,710.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,098,544,031.72</b>	<b>2,553,736,710.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,098,065,946.20	2,545,206,248.82
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,288,424,773.64	1,523,692,887.32
210101	Үндсэн цалин	655,854,162.84	928,162,836.27
210102	Нэмэгдэл	441,291,077.80	483,487,081.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,708,487.00	44,500,000.00
210104	Урамшуулал	92,571,046.00	67,542,970.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	162,685,199.00	198,410,693.73
210201	Тэтгэврийн даатгал	112,503,830.00	135,843,002.91
210202	Тэтгэмжийн даатгал	18,140,943.00	15,640,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,794,067.00	12,518,490.82
210204	Ажилгүйдлийн даатгал	4,386,042.00	3,128,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,860,317.00	31,280,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	118,482,223.09	131,286,539.00

210301	Гэрэл, цахилгаан	20,148,530.00	22,558,189.00
210302	Түлш, халаалт	78,782,200.00	87,238,092.00
210303	Цэвэр, бохир ус	19,551,493.09	21,490,258.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>64,398,016.49</b>	<b>74,829,724.99</b>
210401	Бичиг хэрэг	11,181,359.00	4,011,949.99
210402	Тээвэр, шатахуун	30,036,905.00	35,899,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,382,042.49	4,474,905.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,770,810.00	10,649,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,026,900.00	19,794,780.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>371,635,908.14</b>	<b>450,019,067.93</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	324,112,500.14	393,973,957.55
210502	Хоол, хүнс	42,109,558.00	52,066,045.38
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,413,850.00	3,979,065.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,194,846.00</b>	<b>9,414,520.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	494,820.00
210604	Урсгал засвар	10,694,846.00	8,919,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,610,112.00</b>	<b>6,262,550.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,610,112.00	6,262,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,441,246.00</b>	<b>7,991,999.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,792,000.00	2,497,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	750,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	356,850.00	535,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,320.00	84,459.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,227,216.00	584,000.00
210807	Газрын төлбөр	110,000.00	234,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	94,860.00	99,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	3,120,350.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,193,621.84</b>	<b>143,298,266.85</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,699,621.84	143,298,266.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>478,085.52</b>	<b>8,530,461.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>120,000.00</b>	<b>3,112,088.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120,000.00	3,112,088.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>358,085.52</b>	<b>16,819.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	358,085.52	16,819.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>5,401,554.30</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,401,554.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>170,091,583.43</u></b>	<b><u>112,354,960.68</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>170,091,583.43</u></b>	<b><u>112,354,960.68</u></b>

### 1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,069,840,996.00</b>	<b>2,511,896,398.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,928,512.00</b>	<b>34,499,949.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,928,512.00	34,499,949.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,928,512.00	34,499,949.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,928,512.00	34,499,949.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,036,912,484.00</b>	<b>2,477,396,449.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	932,756,100.00	1,141,720,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	932,756,100.00	1,141,720,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,087,684.00	51,098,002.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,994,184.00	2,244,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,093,500.00	47,853,152.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,074,068,700.00	1,284,578,047.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,074,068,700.00	1,284,578,047.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,048,772,214.00</b>	<b>2,478,486,898.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,048,772,214.00</b>	<b>2,478,486,898.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,048,294,128.48</b>	<b>2,469,252,575.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,290,800,442.80	1,521,305,725.71
210101	Үндсэн цалин	637,895,791.00	925,775,674.66
210102	Нэмэгдэл	462,375,118.80	483,487,081.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,708,487.00	44,500,000.00
210104	Урамшуулал	91,821,046.00	67,542,970.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	162,007,199.00	198,898,005.00
210201	Тэтгэврийн даатгал	111,425,499.00	136,336,505.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,645,400.00	15,640,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,116,300.00	12,512,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,529,100.00	3,128,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,290,900.00	31,280,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	118,113,274.39	131,286,539.00
210301	Гэрэл, цахилгаан	20,148,530.00	22,558,189.00
210302	Түлш, халаалт	78,782,200.00	87,238,092.00
210303	Цэвэр, бохир ус	19,182,544.39	21,490,258.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,670,212.49	77,049,114.99
210401	Бичиг хэрэг	4,256,390.00	3,055,199.99
210402	Тээвэр, шатахуун	28,843,860.00	38,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,853,782.49	4,474,905.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,822,470.00	15,800,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,893,710.00	15,118,030.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	389,549,775.80	505,448,792.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	339,301,397.80	445,158,024.00
210502	Хоол, хүнс	41,610,688.00	50,154,318.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,637,690.00	10,136,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,039,400.00	18,999,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,842,040.00	3,000,000.00
210602	Тавилга	00.00	3,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	635,000.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	12,562,360.00	9,999,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,610,112.00	6,262,550.00
210702	Дотоод албан томилолт	6,610,112.00	6,262,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,503,712.00	10,002,149.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,792,000.00	2,497,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	750,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	356,850.00	535,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,320.00	84,459.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,117,032.00	1,914,500.00
210807	Газрын төлбөр	110,000.00	234,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	94,860.00	99,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,172,650.00	3,800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,000,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>478,085.52</b>	<b>9,234,322.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	120,000.00	3,815,949.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120,000.00	3,815,949.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	358,085.52	16,819.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	358,085.52	16,819.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	5,401,554.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,401,554.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>21,068,782.00</u></b>	<b><u>33,409,500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,068,782.00</b>	<b>33,409,500.00</b>

<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,068,782.00</b>	<b>33,409,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	21,068,782.00	33,409,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,068,782.00	33,409,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-21,068,782.00</b>	<b>-33,409,500.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	715,893,092.00	48,905,110.21	215,894,260.23	980,692,462.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>715,893,092.00</b>	<b>48,905,110.21</b>	<b>215,894,260.23</b>	980,692,462.44
C07	Тайлант үеийн үр дүн	234,000,000.00	00.00	170,091,583.43	404,091,583.43
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>949,893,092.00</b>	<b>270,729,125.14</b>	<b>385,985,843.66</b>	1,606,608,060.80
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>949,893,092.00</b>	<b>270,729,125.14</b>	<b>385,985,843.66</b>	1,606,608,060.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>949,893,092.00</b>	<b>270,729,125.14</b>	<b>385,985,843.66</b>	1,606,608,060.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	112,354,960.68	112,354,960.68
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>949,893,092.00</b>	<b>270,729,125.14</b>	<b>498,340,804.34</b>	1,718,963,021.48

### 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,458,884,600.00	2,455,396,841.70	3,487,758.30	99.86
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,458,884,600.00	2,455,396,841.70	3,487,758.30	99.86
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,456,984,600.00	2,453,500,892.70	3,483,707.30	99.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,521,777,000.00	1,521,305,725.71	471,274.29	99.97
210101	Үндсэн цалин	903,380,000.00	925,775,674.66	-22,395,674.66	102.48
210102	Нэмэгдэл	483,559,000.00	483,487,081.05	71,918.95	99.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,500,000.00	44,500,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	90,338,000.00	67,542,970.00	22,795,030.00	74.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	198,675,200.00	198,675,200.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	136,111,700.00	136,113,700.00	-2,000.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,642,400.00	15,640,400.00	2,000.00	99.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,512,300.00	12,512,300.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,128,100.00	3,128,100.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,280,700.00	31,280,700.00	0.00	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	133,475,100.00	131,286,539.00	2,188,561.00	98.36
210301	Гэрэл, цахилгаан	24,677,700.00	22,558,189.00	2,119,511.00	91.41
210302	Түлш, халаалт	87,341,100.00	87,238,092.00	103,008.00	99.88
210303	Цэвэр, бохир ус	21,456,300.00	21,490,258.00	-33,958.00	100.16
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	73,446,300.00	72,662,114.99	784,185.01	98.93
210401	Бичиг хэрэг	3,055,200.00	3,055,199.99	0.01	100.00
210402	Тээвэр, шатахуун	38,604,700.00	38,600,000.00	4,700.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,253,800.00	4,474,905.00	778,895.00	85.17
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,801,000.00	15,800,980.00	20.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,731,600.00	10,731,030.00	570.00	99.99
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	486,912,200.00	486,911,214.00	986.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	427,620,500.00	427,620,446.00	54.00	100.00
210502	Хоол, хүнс	50,155,000.00	50,154,318.00	682.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,136,700.00	9,136,450.00	250.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,000,000.00	28,999,700.00	300.00	100.00

**Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	4,550,000.00	4,550,000.00	0.00	100.00
210602	Тавилга	12,250,000.00	12,250,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,999,700.00	300.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,361,000.00</b>	<b>4,355,300.00</b>	<b>5,700.00</b>	<b>99.87</b>
210702	Дотоод албан томилолт	4,361,000.00	4,355,300.00	5,700.00	99.87
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,337,800.00</b>	<b>9,305,099.00</b>	<b>32,701.00</b>	<b>99.65</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	750,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	535,200.00	535,140.00	60.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84,500.00	84,459.00	41.00	99.95
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,947,100.00	1,914,500.00	32,600.00	98.33
210807	Газрын төлбөр	234,000.00	234,000.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	99,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1900000.00</b>	<b>1895949.00</b>	<b>4,051.00</b>	<b>99.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,900,000.00</b>	<b>1,895,949.00</b>	<b>4,051.00</b>	<b>99.79</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	1,895,949.00	4,051.00	99.79
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,458,884,600.00</b>	<b>2,460,798,396.00</b>	<b>-1,913,796.00</b>	<b>100.08</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,141,720,400.00</b>	<b>1,141,720,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,141,720,400.00	1,141,720,400.00	0.00	100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,284,578,300.00</b>	<b>1,284,578,047.00</b>	<b>253.00</b>	<b>100.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,284,578,300.00	1,284,578,047.00	253.00	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>32,585,900.00</b>	<b>34,499,949.00</b>	<b>-1,914,049.00</b>	<b>105.87</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,585,900.00	34,499,949.00	-1,914,049.00	105.87
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>95.00</b>	<b>95</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	72.00	72.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	0.00	100.00

## 1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>51,081,183.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51,081,183.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	49,161,183.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	222,805.00
210201	Тэтгэврийн даатгал	222,805.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,387,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,387,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,537,578.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,537,578.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,409,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,409,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,907,250.00
210702	Дотоод албан томилолт	1,907,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	697,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	697,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,920,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,920,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	51098002.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	51,098,002.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,244,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,853,152.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	